



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/242

Чингис хот

Устгалын ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3.3, 3.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль цаг уурын өөрчлөлт, өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн улмаас зүй бусаар үхэж хорогдсон мал, амьтны сэг зэм устгах ажил орон нутагт хангалтгүй байгаа нь цаашид хүн малын халдварт өвчний голомт үүсгэж болзошгүй төдийгүй, дотоод гадаадын аялагчид жуулчидын аялж амрахад сөргөөр нөлөөлж байгаа тул уг ажлыг орон нутгийн иргэдийн оролцоотой шуурхай зохион байгуулж 2018 оны 07 дугаар сарын 10-ны дотор дуусгахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хорогдсон малын сэг зэмийг цуглуулан булж халдваргүйтгэн өвөлжөө, хаваржаан дахь мал, амьтны байр, хашаа саравч, өтөг бууц, түүхий эд хадгалах агуулах, махны зоорь болон мал нядалгааны газар, өвчний голомтуудыг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг мал эмнэлгийн анхан шатны нэгж, мал эмнэлэг үржлийн тасагт даалгасугай.

3. Халдваргүйтгэлийн ажилд оролцож буй малын эмч, туслах ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө, аюулгүй ажиллагааны зааварчлага өгч тусгай зориулалтын халдвар хамгааллын хувцас, хэрэгслээр хангахыг сумын Засаг даргын Тамгын газарт хариуцуулсугай.

4. Устгал, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах эмийн бодисоор хангаж дүнг 2018 оны 07 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

5. Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг, зэмийг устгах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулсан тухай нэгдсэн тайлан мэдээг холбогдох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА